



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/39

Хөхбүрд

Мал, амьтны гоц халдварт “Шүлхий” өвчнөөс
урьдчилан сэргийлэх мэдрэмтгий мал
амьтанг дархлаажуулалтад
хамруулах ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 дугаар заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дугаар заалт, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6, 9.8 дугаар заалт, аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/202 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны гоц халдварт “Шүлхий” өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг 2023 оны 04 дүгээр сарын 24-ны өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрийн хооронд технологит хугацаанд нь үр дүндтэй зохион байгуулж, дүн мэдээг долоо хоног тутам аймгийн мал эмнэлгийн газарт мэдээлж байхыг Мал эмнэлгийн тасаг (Ж.Ёндонпил)-д даалгасугай.

2. Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх намрын дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах “Шуурхай штаб”-ын бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт, Малын гоц халдварт “Шүлхий” өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлын хэсгийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдрэмтгий мал болох үхрийг дархлаажуулалтын ажлыг дээрх заагдсан хугацаанд батлагдсан хувиарын дагуу, технологит хугацаанд нь шуурхай зохион байгуулахыг мал эмнэлгийн үйл ажиллагаа явуулж буй мал эмнэлгийн аж ахуйн нэгжийн малын их эмч Ц.Дандар, Д.Зоригт, Б.Лхагвасүрэн нарт хариуцуулсугай.

4. Мал амьтныг бэлэн байлгаж товолсон хугацаанд бүрэн хамруулж, малыг барьж бэхлэх, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдүүлэх, малын эмчийн аюулгүй байдлыг хангахыг малчид, мал бүхий иргэдэд үүрэг болгосугай.

642301045

3.Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдрэмтгий мал болох үхрийг дархлаажуулалтын ажлыг дээрх заагдсан хугацаанд батлагдсан хувиарын дагуу, технологит хугацаанд нь шуурхай зохион байгуулахыг мал эмнэлгийн үйл ажиллагаа явуулж буй мал эмнэлгийн аж ахуйн нэгжийн малын их эмч Ц.Дандар, Д.Зоригт, Б.Лхагвасүрэн нарт хариуцуулсугай.

4.Мал амьтныг бэлэн байлгаж товолсон хугацаанд бүрэн хамруулж, малыг барьж бэхлэх, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдүүлэх, малын эмчийн аюулгүй байдлыг хангахыг малчид, мал бүхий иргэдэд үүрэг болгосугай.

5.Малчин мал бүхий иргэний үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, шаардлагатай зөвлөмж мэдээллээр ханган ажиллахыг багийн Засаг дарга нар, Мал эмнэлгийн тасаг, аж ахуйн нэгжүүдийн захиралуудад тус тус даалгасугай.

6.Дархлаажуулалтын ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, ажлын явц гүйцэтгэлд хяналт тавьж дүн мэдээг сумын Онцгой комиссын хуралдаанд танилцуулж ажиллахыг сумын Шуурхай штаб (М.Жавзансүрэн)-д үүрэг болгосугай.

7.Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтанд шаардлагатай тээвэр шатахуунаар бүрэн хангах ажлыг Засаг даргын Тамгын газрын шатахууны зардлаас 675,434 (Зургаан зуун далан таван мянга дөрвөн зуун гучин дөрвөн төгрөг)-ийг санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Л.Алимаа)-д зөвшөөрсүгэй.

8.Дээрх ажлын хэсгийн аюулгүй байдлыг хангаж хэв журам сахиулж ажиллахыг сумын хэсгийн төлөөлөгч цагдаагын дэслэгч (С.Дашбалбар), цагдаагийн дэд ахлагч (А.Тогтохбаяр) нарт даалгасугай.

9.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, захирамжын заалтуудыг хэрэгжүүлээгүй зөрчил гаргасан малчид, иргэдийг холбогдох хууль журмын дагуу арга хэмжээ авч ажиллахыг орлогч дарга (Г.Ганцоож)-д даалгасугай.

ДАРГА  Ж.ХАТАНБААТАР

Сумын Засаг даргын 2023. оны 04 дугаар сарын 25-ны
өдрийн 1/3 дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт

МАЛЫН ГОЦ ХАЛДВАРТ ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
МЭДРЭМТГИЙ МАЛЫГ ХАВРЫН ДАРХЛААЖУУЛАЛТЫН
АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, МЭРГЭЖИЛ АРГА
ЗҮЙГЭЭР ХАНГАХ “ШУУРХАЙ ШТАБ” –ЫН
БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: М.Жавзансүрэн – ЗДТГ-ын дарга

Ж.Ёндонпил – Мал эмнэлгийн тасгийн тархварзүйч

Ж.Жамяндагва - Мал эмнэлгийн тасгийн Улсын

байцаагчыг түр орлон гүйцэтгэгч

Т. Цэцэгсайхан–Мандалхайрхан 1-р багийн Засаг

дарга

С.Энх-Амгалан –Уранхайрхан 2-р багийн Засаг дарга

М.Сэр-Од –Асгамба 3-р багийн Засаг дарга

Б.Дагдансүрэн –Мэргэн 4-р багийн Засаг дарга

Л.Гүндцамба – ХААТ-ын дарга

С.Дашбалбар – Хэсгийн төлөөлөгч

А.Тогтохбаяр – Цагдаа

----- оОо -----

Сумын Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 25-ны
өдрийн 1/39 дугаар захирамжийн хоёрдугаар
хавсралт

МАЛЫН ГОЦ ХАЛДВАРТ ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ МЭДРЭМТГИЙ МАЛЫГ ХАВРЫН
ДАРХЛААЖУУЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСЭГ

Асгамба 3 дугаар баг, Мэргэн 4 дүгээр баг

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Дандар - "Эрдэнэт сүргийн хишиг" ХХК-ны малын эмч

Б.Дагдансүрэн - 4 дүгээр багийн Засаг дарга

М.Сэр-Од - 3 дугаар багийн Засаг дарга

Уранхайрхан 2 дугаар баг, Мандалхайрхан 1 дүгээр баг,

Ажлын хэсгийн ахлагч: Б.Лхагвасүрэн "Хишигт тайжын овоо" ХХК-ны малын эмч

С.Энх-Амгалан 2 дугаар багийн Засаг дарга

Т.Цэцэгсайхан - 1 дүгээр багийн Засаг дарга

_____оОо_____